

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/148/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага.....	21
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/182
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.МӨНХЗУЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 734,806.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 98,320.7 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, нягтлан бодогч тооцоо бодсон баримтаар үр дүнг тооцож баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 72.4.1 "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D 2022/2022.02.25 19020533

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,545,155.09</u>	<u>134,442,961.47</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	36,122,292.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	36,122,292.75
3121	Төгрөг	-	36,122,292.75
31211	Төрийн сангийн харилцах		29,318,277.75
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		6,804,015.00
33	АВЛАГА	41,666.48	-
335	Бусад авлага	41,666.48	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	41,666.48	
35	БАРАА МАТЕРИАЛ	60,503,488.61	98,320,668.72
351	Түүхий эд материал	43,678,436.61	70,705,663.72
35110	Тусгай зориулалттай материал	9,944,274.23	15,334,684.23
35130	Эм боох материал	33,734,162.38	55,370,979.49
354	Хангамжийн материал	16,825,052.00	27,615,005.00
35410	Бичиг хэргийн материал	1,012,400.00	1,537,900.00
35420	Аж ахуйн материал	13,792,222.00	25,139,540.00
35460	Хүнсний материал	182,950.00	6,565.00
35470	Бусад хангамжийн материал	1,837,480.00	931,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>735,708,433.92</u>	<u>734,806,705.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	735,708,433.92	734,806,705.49
392	Биет хөрөнгө	712,828,433.92	711,926,705.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	517,403,877.03	517,403,877.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,162,472.54)	(37,042,299.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,980,000.00	132,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,114,666.59)	(92,670,666.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,296,156.94	258,272,706.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,032,181.38)	(72,640,514.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,985,003.00	9,985,003.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,750,882.54)	(5,585,000.74)
39217	Ном	1,223,600.00	1,223,600.00
393	Биет бус хөрөнгө	22,880,000.00	22,880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	22,880,000.00	22,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>796,253,589.01</u>	<u>869,249,666.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>6,492,992.79</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	6,492,992.79
413	Өглөг	-	6,492,992.79
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		26,900.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,466,092.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>796,253,589.01</u>	<u>862,756,674.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	796,253,589.01	862,756,674.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	481,147,295.44	481,147,295.44

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	481,147,295.44	481,147,295.44
512	Хуримтлагдсан үр дүн	227,077,621.52	293,580,706.68
51210	Өмнөх үеийн үр дүн	84,541,985.29	227,077,621.52
51220	Тайлант үеийн үр дүн	142,535,636.23	66,503,085.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,028,672.05	88,028,672.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>796,253,589.01</u>	<u>869,249,666.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	603,764,863.90	661,977,893.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,622,553.90	16,051,338.00
120	Нийтлэг татварын бус орлого	177,622,553.90	16,051,338.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,622,553.90	16,051,338.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	177,622,553.90	16,051,338.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,142,310.00	645,926,555.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	355,526,900.00	405,548,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	355,526,900.00	405,548,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,133,790.00	184,162,855.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,133,790.00	184,162,855.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,671,100.00	24,671,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,671,100.00	24,671,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	31,810,520.00	31,544,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	31,810,520.00	31,544,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	460,492,646.11	595,474,807.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,492,646.11	595,474,807.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,831,213.62	595,474,807.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,798,319.58	331,803,397.38
210101	Үндсэн цалин	201,206,796.10	231,946,521.18
210102	Нэмэгдэл	75,262,364.88	71,330,931.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,890,783.00	2,687,000.00
210104	Урамшуулал	11,438,375.60	25,838,944.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,167,843.89	49,097,107.24
210201	Тэтгэврийн даатгал	25,385,388.80	39,542,275.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,745,120.76	2,541,733.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,186,016.83	1,993,065.87
210204	Ажилгүйдлийн даатгал	531,938.79	415,246.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,319,378.71	4,604,785.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,081,585.04	29,837,192.40
210301	Гэрэл, цахилгаан	2,536,893.04	2,934,874.00
210302	Түлш, халаалт	20,412,832.00	25,710,402.40
210303	Цэвэр, бохир ус	3,131,860.00	1,191,916.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,745,631.86	30,291,310.00
210401	Бичиг хэрэг	2,342,750.00	1,184,150.00
210402	Тээвэр, шатахуун	18,393,720.00	19,704,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	531,630.00	778,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,728,270.00	2,875,930.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,748,000.00
210408	Бараа материал акталсны зардал	5,749,261.86	

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	29,685,679.45	51,824,908.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,901,239.45	29,808,863.79
210502	Хоол, хүнс	5,784,440.00	22,016,045.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,326,720.00	7,711,468.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	419,100.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,986,550.00	6,411,468.60
210604	Урсгал засвар	921,070.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,052,000.00	1,723,655.00
210702	Дотоод албан томилолт	1,052,000.00	1,723,655.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	845,500.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	341,900.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,600.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,127,933.80	93,185,768.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,151,670.00	26,307,490.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,976,263.80	66,878,278.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,661,432.49	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,201,317.53	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,201,317.53	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,397,814.96	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,397,814.96	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,300.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,300.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	143,272,217.79	66,503,085.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	736,581.56	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	736,581.56	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(736,581.56)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	142,535,636.23	66,503,085.16

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,147,295.44	88,028,672.05	84,541,985.29	653,717,952.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	481,147,295.44	88,028,672.05	84,541,985.29	653,717,952.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			142,535,636.23	142,535,636.23
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,147,295.44	88,028,672.05	227,077,621.52	796,253,589.01
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,147,295.44	88,028,672.05	227,077,621.52	796,253,589.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	481,147,295.44	88,028,672.05	227,077,621.52	796,253,589.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			66,503,085.16	66,503,085.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,147,295.44	88,028,672.05	293,580,706.68	862,756,674.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	426,142,310.00	645,926,555.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	355,526,900.00	405,548,200.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	355,526,900.00	405,548,200.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	355,526,900.00	405,548,200.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,615,410.00	240,378,355.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,133,790.00	184,162,855.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,133,790.00	184,162,855.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,671,100.00	24,671,100.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,671,100.00	24,671,100.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	31,810,520.00	31,544,400.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	31,810,520.00	31,544,400.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	423,872,310.00	551,224,362.25	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,872,310.00	551,224,362.25	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,210,877.51	551,224,362.25	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,798,319.61	310,805,287.92	
210101	Үндсэн цалин	201,206,796.13	176,640,920.80	
210102	Нэмэгдэл	75,262,364.88	92,715,336.50	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,890,783.00	3,006,000.00	
210104	Урамшуулал	11,438,375.60	38,443,030.62	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,130,212.86	39,734,601.33	
210201	Тэтгэврийн даатгал	25,347,757.80	28,489,279.99	
210202	Тэтгэмжийн даатгал	2,745,120.76	3,147,032.24	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,186,016.83	2,463,865.88	
210204	Ажилгүйдлийн даатгал	531,938.79	512,220.21	
210205	Эрүүл мэндийн даатгал	5,319,378.68	5,122,203.01	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,081,585.04	23,371,100.00	
210301	Гэрэл, цахилгаан	2,536,893.04	2,934,874.00	
210302	Түлш, халаалт	20,412,832.00	19,889,500.00	
210303	Цэвэр, бохир ус	3,131,860.00	546,726.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	22,893,720.00	34,248,730.00	
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,027,250.00	
210402	Тээвэр, шатахуун	18,393,720.00	19,704,900.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,460,730.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,999,850.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,056,000.00	
2105	Нормативт зардал	21,095,490.00	74,268,619.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,128,100.00	53,662,389.00	

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	5,967,390.00	20,606,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,908,000.00	8,407,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,269,100.00	3,015,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,447,200.00	4,092,000.00
210604	Урсгал засвар	1,191,700.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,052,000.00	1,550,000.00
210702	Дотоод албан томилолт	1,052,000.00	1,550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,660,800.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	228,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,590,750.00	58,839,024.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,590,750.00	58,839,024.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,661,432.49	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,460,114.96	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,460,114.96	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,201,317.53	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,201,317.53	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,270,000.00</u>	<u>94,702,192.75</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,270,000.00	58,579,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,270,000.00	58,579,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,270,000.00	58,579,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,270,000.00	58,579,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,270,000.00)</u>	<u>(58,579,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	36,122,292.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		36,122,292.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	461,847,000.0	432,445,422.3	29,401,577.8	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,847,000.0	432,445,422.3	29,401,577.8	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,847,000.0	432,445,422.3	29,401,577.8	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	329,759,000.0	310,805,287.9	18,953,712.1	94.3
210101	Үндсэн цалин	206,346,000.0	176,640,920.8	29,705,079.2	85.6
210102	Нэмэгдэл	86,665,300.0	92,715,336.5	(6,050,036.5)	107.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,796,000.0	3,006,000.0	2,790,000.0	51.9
210104	Урамшуулал	30,951,700.0	38,443,030.6	(7,491,330.6)	124.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,517,700.0	39,734,601.3	4,783,098.7	89.3
210201	Тэтгэврийн даатгал	31,327,400.0	28,489,280.0	2,838,120.0	90.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,297,600.0	3,147,032.2	150,567.8	95.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,638,100.0	2,463,865.9	174,234.1	93.4
210204	Ажилгүйдлийн даатгал	659,500.0	512,220.2	147,279.8	77.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,595,100.0	5,122,203.0	1,472,897.0	77.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,371,100.0	23,371,100.0	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,964,100.0	2,934,874.0	1,029,226.0	74.0
210302	Түлш, халаалт	19,107,000.0	19,889,500.0	(782,500.0)	104.1
210303	Цэвэр, бохир ус	300,000.0	546,726.0	(246,726.0)	182.2
2104	Хангамж, бараа материалын зардал	21,960,000.0	21,947,830.0	12,170.0	99.9
210401	Бичиг хэрэг	1,000,000.0	1,027,250.0	(27,250.0)	102.7
210402	Тээвэр, шатахуун	17,460,000.0	17,460,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.0	1,460,730.0	39,270.0	97.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,999,850.0	150.0	100.0
2105	Нормативт зардал	25,539,200.0	25,537,979.0	1,221.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,539,200.0	16,538,299.0	901.0	100.0
210502	Хоол, хүнс	9,000,000.0	8,999,680.0	320.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,400,000.0	8,377,000.0	23,000.0	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.0	2,985,000.0	15,000.0	99.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,100,000.0	4,092,000.0	8,000.0	99.8
210604	Урсгал засвар	1,300,000.0	1,300,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.0	1,550,000.0	950,000.0	62.0
210702	Дотоод албан томилолт	2,500,000.0	1,550,000.0	950,000.0	62.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.0	1,121,624.0	4,678,376.0	19.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.0	1,121,624.0	4,678,376.0	19.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	461,847,000.0	461,763,700.0	83,300.0	100.0

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	405,548,200.0	405,548,200.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,548,200.0	405,548,200.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,671,100.0	24,671,100.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	24,671,100.0	24,671,100.0	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,627,700.0	31,544,400.0	83,300.0	99.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	31,627,700.0	31,544,400.0	83,300.0	99.7
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.0	18.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.0	13.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.0	4.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,358,840.00	177,358,840.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,778,940.00	118,778,940.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	118,778,940.00	118,778,940.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	12,300,900.00	12,300,900.00	
210402	Тээвэр, шатахуун	2,244,900.00	2,244,900.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,056,000.00	10,056,000.00	
2105	Нормативт зардал	48,730,640.00	48,730,640.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,124,090.00	37,124,090.00	
210502	Хоол, хүнс	11,606,550.00	11,606,550.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,747,400.00	57,747,400.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	57,747,400.00	57,747,400.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,579,900.00	58,579,900.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	58,579,900.00	58,579,900.00	
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,579,900.00	58,579,900.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	184,162,855.00	184,162,855.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	184,162,855.00	184,162,855.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	184,162,855.00	184,162,855.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	6,804,015.00	6,804,015.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,804,015.00	6,804,015.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад эрх бүхий дээд байгууллагын гаргасан шийдвэрийг мөрдөж ажиллах, эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж байх, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаж байх, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, НББ-ийг аккурэл сууриар хөтөлж, бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнахгүй ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь бүхний эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэн, сумын эрүүл мэндийн төвийн стандартын хангалтыг сайжруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гарган батлуулж,

дотоод үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын тайланг улирал бүр тайлагнасан байна.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 461,847.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,927.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,195.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 461,847.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 461,763.7 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 184,162.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 551,224.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 65,976.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19,539.3 мянган төгрөгийн, нийт 65,976.6 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 64,476.6 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 8,225.4 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 124,055.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 96,718.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэлгүй, 6,493.0 мянган өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 29,318.3 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 6,804.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 96,090.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 734,806.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	36,122.3	36,122.3
Авлага	41.7	-	(41.7)
Урьдчилгаа			-
Бараа материал	60,503.5	96,090.7	35,587.2
Үндсэн хөрөнгө	735,708.4	734,806.7	(901.7)
Нийт хөрөнгө	796,253.6	867,019.7	70,766.1
Өр төлбөр	-	6,493.0	6,493.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	796,253.6	860,526.7	64,273.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	796,253.6	867,019.7	70,766.1

Бараа материалын дансны үлдэгдэл 96,090.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 35,587.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 734,806.7 мянган төгрөг болж 901.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлээс шалтгаалж байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 860,526.7 мянган төгрөг болж 64,273.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 643,948.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 643,948.5 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 182,101.5 мянган төгрөг буюу 28.2 хувиар бууруулж, 461,847.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 405,548.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 24,671.1 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 31,544.4 мянган төгрөгийн, нийт 461,763.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 432,445.4 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 29,318.3 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 432,445.4 мянган төгрөг буюу 93.6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 184,162.9 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 118,778.9 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 58,579.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 6,804.0 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бүрэн сумын Эргэлтийн эмийн сан нь 14,571.5 мянган төгрөгийн эмийн борлуулалтын орлогыг и-баримтаар баталгаажуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 35,587.2 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 өвчний үед шаардлагатай эм бэлдмэл, хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодисын бэлэн байдлыг хангах зорилгоор бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт бүрэн зарцуулж, уг үйл ажиллагааг санхүүгийн тайланд толилуулсан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 734,806.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 98,320.7 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, нягтлан бодогч тооцоо бодсон баримтаар үр дүнг тооцож баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж

заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 124 мэдээллийг хугацаандаа, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13,974.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 138,283.4 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 37,515.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,186.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 27,423.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 72,157.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 37,515.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулгахад санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт үр дүн 37,515.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,186.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 10 албан хаагчид вакцины урамшуулалт цалин олгохдоо НДШ-ийг суутган тооцолгүй, зөвхөн ХХОАТ-ыг суутган тооцсоны улмаас гарт олгох урамшуулалт цалинг 1,090.1 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. 2021 оны 4 дүгээр сард 1 албан хаагчид үр дүнгийн урамшуулалт цалин олгохдоо Байгууллагын даргын тушаалаар баталсан хувийг нэмэгдүүлэн тооцож 96.3 мянган төгрөгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 27,423.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлэв.

Үүнд:

1. Бүрэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор 16 нэр төрлийн 13,974.3 мянган төгрөгийн хөрөнгийг дахин ашиглах, хугацааг уртасгаж данс бүртгэлд тусгах шийдвэр гарсныг биелүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацааны худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 7 харилцагч байгууллагын нийт 13,449.1 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6-д "Тооцооны маягтыг нөхөх заавар 5.Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 124 мэдээллийг хугацаандаа, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тус ЭМТ-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2 нэр төрлийн 60,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашин /УАЗ-469, Мицубуши Делика/-ыг Бүрэн сумын Засаг даргын Тамгын газарт балансаас баланст шилжүүлэх шийдвэр гарсныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий дээд байгууллагын гаргасан шийдвэрийг мөрдөж ажиллах

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн Санхүүгийн тайланд 10,693.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэн зөв байдал", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаж байх

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцэст хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, тооллоготой холбоотой баримт материалыг аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж байх

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 1,264.6 мянган төгрөгийн хоол хүнсний материалыг бараа материалын орлого авалгүй өглөгийн данснаас шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний

стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн аккруэл сууриар хөтөлж, бараа материалыг шууд зардлаар бүртгэхгүй байх

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Цалингийн тооцооны хүснэгт бэлтгэдэггүй, цалинтай холбоотой анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв	11	138,283.4	1	37,515.9	2	1,186.4	3	27,423.4	5	72,157.3

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn